



МОНГОЛ УЛСЫН
БОЛОВСРОЛЫН ИХ СУРГУУЛИЙН
РЕКТОРЫН ТУШААЛ

2024 оны 03 сарын 13 өдөр

Дугаар А/25

Улаанбаатар хот

Цахим сургалтын журмыг
шинэчлэн батлах тухай

Дээд боловсролын тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1.2, МУБИС-ийн дүрмийн 4.4.1, 4.4.5, МУБИС-ийн "Багшийн ажиллах журам"-ын 4.2.28, МУБИС-ийн Ректорын зөвлөлийн 2024 оны 03 дугаар сарын 05-ны өдрийн хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Монгол Улсын Боловсролын Их Сургуулийн "Цахим сургалтын журам"-ыг шинэчлэн хавсралтаар баталсугай.

2. "Цахим сургалтын журам"-ыг оюутан, багш, ажилтнуудад танилцуулж, батлагдсан өдрөөс эхлэн үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллахыг бүрэлдэхүүний сургуулийн захирлууд, албадын дарга нар, мэргэжилтнүүдэд үүрэг болгосугай.

3. Цахим хичээл боловсруулсан багш (баг)-д 1 кредит тутамд 1,5 кредит цагийн хөлсийг нэмэлт кредитийн өртгөөр тооцож олгохыг бүрэлдэхүүний сургуулийн захирлуудад үүрэг болгосугай.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Сургалт, хамтын ажиллагааны газрын дарга (Д.Соронзон)-д үүрэг болгосугай.

5. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан МУБИС-ийн захирлын 2019 оны 02 дугаар сарын 25-ны өдрийн А/52 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

РЕКТОР



Ж.БАТБААТАР

МУБИС-ИЙН ЦАХИМ СУРГАЛТЫН ЖУРАМ

НЭГ. Нийтлэг үндэслэл

- 1.1. Энэхүү журмын зорилго нь цахим сургалт явуулах, таатай орчин бүрдүүлэх, цаг хугацаа орон зайнаас үл хамааран суралцах, чөлөөт сонголт хийх боломжийг нэмэгдүүлэх, хөтөлбөрийн тоо, хүртээмж, чанарыг дээшлүүлэхэд оршино.
- 1.2. Тус журам нь Монгол Улсын боловсролын хууль, тогтоомж, төрийн байгууллагаас гаргасан дүрэм, журам, МУБИС-ийн дотоод дүрэм журмын хүрээнд МУБИС-д цахим сургалт зохион байгуулах, түүнтэй холбогдон үүсэх харилцааг зохицуулна.
- 1.3. Багшийн цахим сургалтын цагийн гүйцэтгэлийг МУБИС-ийн "Багшийн ажиллах журам"-д заасны дагуу, оюутны үнэлгээг МУБИС-ийн "Оюутны үнэлгээний журам"-ын дагуу тус тус тооцно.
- 1.4. Цахим сургалтын хүрээнд уг журмаар зохицуулагдахгүй асуудлыг "Сургалтын журам" эсвэл МУБИС-ийн Ректорын зөвлөлөөр хэлэлцэж, шийдвэр гаргана.

ХОЁР. Хамрах хүрээ

- 2.1. МУБИС-ийн бакалавр болон ахисан түвшний (магистр, доктор), нэмэлт хөтөлбөрийн цахим сургалтыг зохион байгуулахад энэхүү журмыг дагаж мөрдөнө.

ГУРАВ. Журмын нэр томьёо

- 3.1. **Асинхрон цахим сургалт (Asynchronous e-learning)**-Суралцагч багшаас хамаарахгүйгээр цахим сургалтын үйл ажиллагаанд оролцох хэлбэр
- 3.2. **Бие даан сурах цахим сургалт (Self-paced e-learning)**-Суралцагч онлайн курс хичээлийн багц материалыг багшаас хамаарахгүйгээр судалж, цахим үнэлгээтэй даалгавар болон тестийг бие даан гүйцэтгэж, СУМС-д суралцагчийн дүн автоматаар тооцогдох хэлбэр
- 3.3. **Зааварлагч багштай цахим сургалт (Instructor-led and facilitated e-learning)**-Онлайн хичээлийн хөтөлбөрийн дагуу зааварлагч багш сургалтын үйл ажиллагааг удирдан чиглүүлж, зохион байгуулах хэлбэр
- 3.4. **Интерактив агуулга (interactive content)**-Суралцагчдыг идэвхтэй үйл ажиллагаанд хамруулах боломжтой буюу суралцагч, агуулгатай тодорхой хэмжээнд харилцаа үүсгэх боломжтой цахим хэрэглэгдэхүүн
- 3.5. **Мультимедиа (Multimedia)**-Дижитал мэдээллийг текст, зураг, аудио, видео, анимейшн гэж 5 ангилдаг. Эдгээрийг хослуулан ашигласан хэлбэрийг мультимедиа (Multimedia) гэнэ. Medium (харилцаа холбоогоор мэдээлэл дамжуулах орчин) гэдэг үгийн олон тоо нь media. Энэ нь хэвлэмэл цаасан дээрх мэдээллийг дижитал мэдээлэл рүү хөрвүүлсэн гэсэн утгатай.
- 3.6. **Онлайн хичээл (online course)**-Хичээлийн материалыг суралцагчдад цаг хугацаа, орон зайнаас үл хамааран мэдээллийн технологи ашиглаж бие даан судлах боломжтой хэлбэрээр зохиомжлон бэлтгэсэн багц хичээл
- 3.7. **Онлайн сургалт (online learning)**-Онлайн сургалт гэдэг нь сургалтын үйл ажиллагааг интернэт сүлжээтэй орчинд зайнаас LMS-ийн тусламжтайгаар зохион байгуулах үйл ажиллагаа
- 3.8. **Синхрон цахим сургалт (Synchronous e-learning)**-Багш болон суралцагч ижил цаг хугацаанд цахим сургалтын үйл ажиллагаанд оролцох хэлбэр

- 3.9. **Сургалтын удирдлага мэдээллийн систем, СУМС (Learning management system)**- Сургалтын үйл ажиллагааг цахим технологиор зохион байгуулах иж бүрэн программын шийдэл
- 3.10. **Тонгоруу сургалт (Flipped Learning)**-Хичээлийн лекцийг цахимаар хүргэж, түүнийг бататгах семинар, лаборатори, практикийн хичээлийг танхимд зохион байгуулах, хосолсон сургалтын арга зүй
- 3.11. **Хосолсон сургалт (Blended learning)**-Сургалтын үйл ажиллагааг цахим технологиос гадна шаардлагатай үйл ажиллагааг танхимаар зохион байгуулах үйл ажиллагаа
- 3.12. **Цахим агуулга (e-content)**-Цахим агуулга (үзэгч, хэрэглэгч эсвэл суралцагч руу хандсан мэдээлэл). Үүнийг ярилцлага, хурал, тайзны үзүүлбэр, хичээл зэргийг интернэт, кино театр, CD, e-ном, сонин, сэтгүүл, шууд дамжуулалт, онлайн хичээл зэрэг ялгаатай орчноор дамжуулж болно.
- 3.13. **Цахим сургалт (E-learning)**- Интернэт сүлжээ, мэдээлэл, харилцаа холбооны технологи (МХХТ)-д суурилсан сургалтын үйл ажиллагаа
- 3.14. **Цахим сургалтын агуулгын шаардлага (E-learning content requirements)**-хичээлийн хөтөлбөрт тусгагдсан агуулга нь академик түвшинд нийцсэн, онолын хувьд үнэ цэнтэй байхаар боловсруулсан эсэхийг тодорхойлох шаардлага
- 3.15. **Цахим хэрэглэгдэхүүн (e-material)**- Цахим сургалтын үйл ажиллагааг идэвхжүүлэхэд ашиглагддаг хэрэгсэл

ДӨРӨВ. Цахим сургалтын хэлбэр, зохион байгуулалт

- 4.1. Цахим сургалтыг онлайн болон хосолсон хэлбэрээр зохион байгуулна. Цахим сургалтыг онлайн курс хичээл ашиглан хэрэгжүүлэх бөгөөд сургалтын үйл ажиллагааг синхрон, асинхрон байдлаар зохион байгуулна.
- 4.2. Ахисан түвшин, нэмэлт, хөрвөх, зэрэг ахиулах хөтөлбөрийн хувьд бие даан сурах цахим сургалтыг, бусад түвшинд зааварлагч багштай цахим сургалтыг ашиглана.
- 4.3. Дараах хичээл, хөтөлбөрийг шаардлага хангасан тохиолдолд онлайн хэлбэрээр зохион байгуулж болно. Үүнд:
- 4.3.1. Нэмэлт, хөрвөх, зэрэг ахиулах, түргэвчилсэн, ахисан түвшний хичээл, хөтөлбөрүүд
- 4.3.2. Лекц, семинартай хичээл
- 4.4. МУБИС-ийн бүх төрлийн хичээл, хөтөлбөрийг шаардлага хангасан тохиолдолд хосолсон хэлбэрээр зохион байгуулж болно. Хосолсон сургалтад тонгоруу сургалтын арга зүйг ашиглах бөгөөд хичээлийн агуулга, арга зүй, үнэлгээг уян хатан, олон талт байхад үндэслэнэ.
- 4.5. Мэргэжлийн хөтөлбөр иж бүрэн онлайн байх эсэх болон сургалтын төлөвлөгөөнд буй онлайн болон танхимын хичээлийн харьцааг мэргэжлийн тэнхимийн саналыг үндэслэн, МУБИС-ийн цахим хөтөлбөрийн дэд хороо тогтооно.
- 4.6. Лаборатори, практик хичээлийг танхимаар зохион байгуулах бөгөөд дараах тохиолдолд онлайн болон хосолсон хэлбэрээр зохион байгуулж болно. Үүнд:
- 4.6.1. Байгалийн давагдашгүй хүчин зүйл, нийтийг хамарсан цар тахал, онцгой байдлын үед;
- 4.6.2. "Сургалтын журам"-ын 4.5.17- д заасны дагуу; (бүлэг бүрдээгүй)
- 4.6.3. Боловсролын ерөнхий хуулийн 12.16 дахь заалтын дагуу МУБИС-аас гаргасан журмын хүрээнд оюутан хүсэлт гаргасан бол;

- 4.7. Лаборатори, практик хичээлийг онлайнаар зохион байгуулахад виртуал лаборатори болон тоног төхөөрөмж, программ хангамжийг бүрдүүлсэн байна.
- 4.8. МУБИС-ийн цахим сургалтыг (Сургалтын удирдлага, мэдээллийн систем)-ээр явуулах бөгөөд МУБИС-ийн Ректорын зөвлөл ямар системийг хэчнээн хугацаанд ашиглахыг тогтооно.
- 4.9. Онлайн хичээлийг энэхүү журмын 5 дахь хэсэгт заасан бүтэц, бүрдэлтэйгээр шаардлагын дагуу боловсруулж баталгаажуулан хэрэгжүүлнэ.
- 4.10. Цахим сургалтын төлбөрийн хэмжээ, нэг кредитийн үнэлгээг өөрөөр тогтоож болох бөгөөд сургуулийн Удирдах зөвлөлөөр батлуулна
- 4.11. МУБИС-ийн цахим сургалтад үндсэн суралцагчдаас бусад иргэд сонгон суралцах нь нээлттэй бөгөөд энэ тохиолдолд тухайн иргэнтэй гэрээ байгуулна. Тухайн иргэн МУБИС-д элсэн суралцах тохиолдолд цахим сургалтаар үзсэн хичээлийг дүйцүүлэн тооцож болно.

ТАВ. Онлайн хичээлийн боловсруулалт, бүтэц

- 5.1. Онлайн хичээлийг МУБИС-ийн үндсэн багш, зөвлөх профессор дангаар эсвэл баг (багш, видео графикч, хэрэглэгдэхүүн хөгжүүлэгч, дизайнер)-аар боловсруулж болно.
- 5.2. Онлайн хичээлийг уг журмын хавсралтад заасан МУБИС-ийн онлайн хичээлийн шаардлагын дагуу боловсруулна.
- 5.3. МУБИС-ийн цахим сургалт хариуцсан нэгж, мэргэжилтэн онлайн хичээлийн интерактив агуулга, мультимедиа, цахим хэрэглэгдэхүүнийг бэлтгэх тохиолдолд хөтөлбөр хэрэгжүүлэгч багш болон мэргэжлийн тэнхимээс зөвлөгөө авна.
- 5.4. Онлайн хичээлийг боловсруулахад шаардлагатай төсвийг хөтөлбөр хэрэгжүүлж буй бүрэлдэхүүний сургууль хариуцах бөгөөд тухайн сургууль хичээлийн жилийнхээ төсөвт заавал тусгасан байна. Нэг хичээл боловсруулахад шаардагдах зардлын хэмжээг МУБИС-ийн Ректорын зөвлөл тогтооно.
- 5.5. Боловсруулсан онлайн хичээлийн хөтөлбөр, түүний иж бүрдлийг мэргэжлийн тэнхим, бүрэлдэхүүн сургуулийн хөтөлбөрийн салбар хороогоор хэлэлцэж, онлайн хичээлд тавигдах шаардлагыг хангасан тухай дүгнэлт гаргана. Уг дүгнэлтийг МУБИС-ийн цахим хөтөлбөрийн дэд хороогоор хэлэлцэж баталгаажуулна.
- 5.6. Онлайн хичээл нь дараах бүтэцтэй байна. Үүнд:
- 5.6.1. Онлайн хичээл нь танилцуулга, хичээлийн төлөвлөлт (сэдэв, модуль, сургалтын үйл ажиллагаа, тэдгээрийн төлөвлөлт), цахим хэрэглэгдэхүүн (мультимедиа, нээлттэй эхийн нөөц материал, интерактив), лекц, семинарын арга зүй (уг журмын 4.6-д заасан онцгой тохиолдолд лаборатори, практик), хэлэлцүүлэг, үнэлгээ (суралцагчийн бие даан гүйцэтгэх ажил, хичээлийн явцын болон эцсийн үнэлгээний даалгавар, тест), нэмж судлах материал (цахим ном, сурах бичгийн жагсаалт) гэсэн бүтэцтэй байна. Шаардлагатай тохиолдолд тэгш хамруулах боловсролд нийцүүлэн цахим агуулгын видео хэрэглэгдэхүүнд дохионы хэл, тайлбар бичиг (subtitle)-ийг нэмж тусгаж болно.
- 5.6.2. Онлайн хичээлийн хөтөлбөр нь зорилго, зорилт, жишиг төлөвлөгөө, ээлжит хичээлийн арга зүй, үнэлгээ гэсэн бүрэлдэхүүн хэсэгтэй байх ба эдгээрийг СУМС-д танилцуулга хэлбэрээр байршуулсан байна.
- 5.6.3. Онлайн лекцийг суралцагч шинжлэх ухааны онолын суурь мэдлэгийг системтэй эзэмших нөхцөлийг хангаж боловсруулсан байна. Онлайн лекц нь видео лекц, уншиж судлах үндсэн материал, нэмэлт материал (эх сурвалж, нэр томьёо, тулгуур

- ухагдахууны лавлагаа, тайлбар болон нэмэлт мэдээлэл) гэсэн 3 хэсгээс бүрдэнэ. Синхрон эсвэл асинхрон хэлбэрээр зохион байгуулж болно.
- 5.6.4. Онлайн семинар - Тухайн хичээлийн онолын гүнзгийрүүлэн судлах, ерөнхийлөн дүгнэх, шүүмжлэлт сэтгэлгээг хөгжүүлэх, мэдлэг хуримтлуулах, бүтээлч санаачилга болон ур чадварт суралцах, эргэцүүлэл хийх, өөрийн үзэл бодлыг үндэслэлтэй хамгаалах дадал бүрдүүлэхэд чиглэсэн зураг, график, тооцоолол бүхий мультимедиа, интерактив үзүүлэн материал байна. Синхрон буюу вебинар хэлбэрээр зохион байгуулж болно.
- 5.6.5. Онлайн лаборатори - Аудио, видео хэлбэртэй дасгал ажлын заавар, удирдамжаас гадна виртуал, симуляци хэрэглэгдэхүүнүүд байж болно.
- 5.6.6. Онлайн үнэлгээтэй даалгавар болон бие даалтын ажил- Зөвлөмж, заавар бүхий удирдамж, үнэлгээний шалгуурыг агуулсан байх бөгөөд удирдамжийг текст, зураг, аудио, видео хэлбэрээр өгч болно.
- 5.6.7. Онлайн үнэлгээний тест, тестийн сан - Олон төрлийн тест (үнэн эсвэл худал, нэг хариулт сонгох, олон хариулт сонгох, харгалзуулах, дараалалд оруулах, нөхөх, бичиж хариулах, файл илгээх)-ийг агуулсан, ялгаатай түвшин (Блүүмийн 6 түвшин)-ийг тестүүдээс санамсаргүй сонгогдох боломжтой, тест болон түүний хариултад текст, зураг, аудио, видео зэргийг ашигласан байж болно.
- 5.6.8. Онлайн хичээлийн нэмж судлах материал – Цахим ном (PDF, epub, html, flipbook, djvu өргөтгөлтэй), сонсох агуулга (подкаст, аудио файлууд, сонсдог ном), видео, үзүүлэн, вики холбоос, эрдэм шинжилгээ судалгааны онлайн веб сайт, сан байж болно.
- 5.7. Онлайн хичээлийг боловсруулахдаа хөгжлийн ялгаатай оюутан, суралцагчдад хүртээмжтэй байхад заавал анхаарсан байна.
- 5.8. Боловсруулсан онлайн хичээлийг ашиглах хугацаа 2-3 улирал байх бөгөөд боловсруулсан багш, баг, тэнхим, суралцагчдын саналд үндэслэн шинэчилнэ.

ЗУРГАА. Онлайн хичээлийн сонголт, дүн баталгаажуулалт

- 6.1. Хичээл сонголт, дүн баталгаажуулалт зэрэг сургалтын үйл явцтай холбоотой бүх харилцааг зохицуулахдаа МУБИС-ийн "Сургалтын журам"-ын холбогдох заалтыг баримтална.

ДОЛОО. Цахим сургалтад оролцогч талуудын эрх, үүрэг хариуцлага

- 7.1. **МУБИС-ийн цахим хөтөлбөрийн дэд хороо**
- 7.1.1. Дээд боловсролын хууль, тогтоомж, МУБИС-ийн сургалтын болон хөгжлийн бодлого, мэдээллийн технологийн хөгжил, хандлага, зах зээлийн эрэлт хэрэгцээтэй уялдуулах;
- 7.1.2. Цахим сургалтын хөтөлбөрийн ерөнхий шаардлага, бүтэц, шалгуур үзүүлэлт, цагийн багтаамж, оюутны сонголт хийх боломж зэргийг нарийвчлан тогтоох;
- 7.1.3. МУБИС-ийн цахим сургалтын хөтөлбөрийн стандарт, шаардлагатай холбоотой бодлого тодорхойлох, хөтөлбөрийг батлах, хэрэгжилтэд хяналт тавих, үнэлэх;
- 7.1.4. Онлайн хичээл, хөтөлбөрт тавих шаардлагыг хангасан эсэх талаарх бүрэлдэхүүний сургуулийн хөтөлбөрийн салбар хорооны дүгнэлтийг баталгаажуулах;
- 7.2. **Бүрэлдэхүүн сургууль**
- 7.2.1. Онлайн хичээл болон иж бүрэн онлайн хөтөлбөр боловсруулах үндсэн багш, зөвлөх профессор эсвэл баг бүрдүүлэн хичээл зохион байгуулах багш нартай гэрээ байгуулах;

- 7.2.2. Гэрээ байгуулсан багшийн ажлын гүйцэтгэлд хяналт тавьж хүлээн авах, сунгах, цуцлах тухай шийдвэр гаргах;
- 7.2.3. Онлайн хичээл болон онлайн хөтөлбөр боловсруулахтай холбоотой зардлыг санхүүжүүлэх;
- 7.2.4. Онлайн хичээл явуулах орчин, нөхцөлийг бүрдүүлэх;
- 7.2.5. Гадаад, дотоодын их дээд сургууль, байгууллагуудын цахим сургалт зохион байгуулж буй туршлагыг судлах, харилцаа холбоо тогтоож, хамтарсан хөтөлбөр, төсөл хэрэгжүүлэх;
- 7.2.6. Цахим сургалтын хэрэгжилтийг үнэлж дүгнэх;
- 7.3. Тэнхим**
- 7.3.1. Өөрийн хэрэгжүүлж буй хөтөлбөрийн хичээлүүдийг онлайн хэлбэрт шилжүүлэх санал гаргах;
- 7.3.2. Тэнхимийн хэрэгжүүлдэг хичээлүүдийг онлайн хэлбэрт шилжүүлэх талаар төлөвлөгөө гаргаж ажиллах;
- 7.3.3. Төлөвлөгөөний дагуу онлайн хичээл боловсруулах саналаа бүрэлдэхүүн сургуулийн захиргаанд хүргүүлэх, уламжилж шийдвэрлүүлэх;
- 7.3.4. Онлайн хичээлийн агуулгыг шалгуур үзүүлэлтийн дагуу хянаж, дүгнэлт, үнэлгээ гаргах;
- 7.4. Онлайн хичээл боловсруулах багш**
- 7.4.1. МУБИС-ийн мультимедиа студийг ашиглах, мэргэжилтнүүдээс зөвлөгөө, тусламж авах;
- 7.4.2. Онлайн хичээлийг боловсруулахад шаардлагатай тоног төхөөрөмж, программ хангамжийг ашиглах, худалдан авахад шаардлагатай санхүүгийн төсвийн хүсэлтийг бүрэлдэхүүний сургуульд гаргах;
- 7.4.3. Онлайн хичээл болон хөтөлбөр боловсруулах, хөгжүүлэхтэй холбоотой сургалтад хамрагдах;
- 7.4.4. Онлайн хичээлийн агуулга, цахим хэрэглэгдэхүүнийг шаардлагын дагуу боловсруулах;
- 7.5. Онлайн хичээл зохион байгуулах багш**
- 7.5.1. Онлайн хичээлийг зохион байгуулах арга зүйн сургалтад хамрагдах;
- 7.5.2. Онлайн хичээлийн хөтөлбөр, удирдамжийг мөрдөж, хуваарийн дагуу чанартай зохион байгуулах;
- 7.6. Суралцагч**
- 7.6.1. Цахим сургалтын талаар дэлгэрэнгүй мэдээлэл авах, цахим сургалтын чанарыг сайжруулах талаар саналаа илэрхийлэх;
- 7.6.2. Цахим сургалтын журам, зөвлөмж, онлайн хичээлийн танилцуулгыг үзэж судалсан байх;
- 7.6.3. Цахим сургалтын системд бүртгүүлсэн холбогдох нэр, нууц үгийг бусдад дамжуулахгүй, системд нэвтэрч ажилласны дараа гарах үйлдлийг заавал хийсэн байх;
- 7.6.4. Цахим сургалтад ашиглагдаж буй цахим хэрэглэгдэхүүн аудио, видео хэрэглэгдэхүүн болон холбогдох файл, бие даалт, үнэлгээний даалгаврыг бусдад дамжуулахгүй байх;
- 7.6.5. Энэхүү журмын 4.6.3 дахь хэсэгт заасан хүсэлт гаргах;
- 7.7. Сургалтын бодлого, зохицуулалтын нэгж**
- 7.7.1. Цахим сургалтын бодлогыг тодорхойлох, хэрэгжилтэд хяналт тавих;
- 7.7.2. Цахим сургалтын үйл ажиллагааг удирдлага, зохион байгуулалтаар хангах;

- 7.7.3. Цахим сургалтын үйл явц, зохион байгуулалт, үр дүн, чанарт үнэлгээ хийх, сайжруулах чиглэл гаргах;
- 7.8. **Цахим сургалт хариуцсан нэгж**
- 7.8.1. Цахим сургалтын системийг тасралтгүй ажиллагааг хангах, шаардлагад нийцүүлэн хөгжүүлэх, шинэчлэх, тасралтгүй сайжруулах ажлыг гүйцэтгэх;
- 7.8.2. Онлайн хичээлийн эх хувилбарыг улирал бүр архивлан хадгалах ажлыг зохион байгуулах;
- 7.8.3. СУМС болон цахим сургалтын системийн нууцлал, аюулгүй байдлыг ханган ажиллах
- 7.8.4. Цахим сургалттай холбоотой мэдээ, тайланг цаг тухайд нь гарган холбогдох алба нэгжид хүргэх;
- 7.8.5. Хөгжлийн ялгаатай суралцагчдад шийдлийг цахим сургалтын системд тусгах, тэдгээр суралцагчдад зориулсан зөвлөгөө мэдээллийг өгөх;
- 7.8.6. Онлайн хичээлд зориулан подкаст, аудио болон видео бичлэг хийх студи, техник, тоног төхөөрөмж, программ хангамжийн бэлэн байдал, хэвийн ажиллагааг хангах;
- 7.8.7. Багш нарын цахим хэрэглэгдэхүүн бүтээх, хөгжүүлэх үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, онлайн хичээлийн төлөвлөлт, суралцахуйн дизайны онол, арга зүйн зөвлөгөө өгөх;
- 7.8.8. Онлайн хичээл боловсруулах, цахим сургалт зохион байгуулах арга зүй, аргачлалын талаар багш нарт зориулсан сургалт зохион байгуулах, гарын авлага, удирдамж боловсруулах;
- 7.8.9. Суралцагчдад зориулсан сургалт зохион байгуулах, цахим сургалтад суралцахтай холбоотой зөвлөгөө, заавар бүхий видео, мультимедиа контент боловсруулж түгээх;
- 7.9. **Номын сан**
- 7.9.1. Үндсэн сурах бичгүүд болон бусад шаардлагатай ном, гарын авлагыг хууль тогтоомж, дүрэм журмын хүрээнд цахим хэлбэрт шилжүүлэх, сургалтын мэдээллийн санд оруулах, суралцагчдад хүргэх ажлыг зохион байгуулах;
- 7.9.2. Цахим ном, сурах бичиг, гарын авлага, материалыг хэрэглэх заавар, зөвлөмж гаргаж суралцагчдад хүргэж түгээн ажиллах;
- 7.9.3. Цахим сурах бичиг, ном, гарын авлагын хүртээмжийг нэмэгдүүлэх талаар арга хэмжээ авч хэрэгжүүлэх;
- 7.9.4. Багш, суралцагчдад зориулсан эрдэм шинжилгээ, судалгааны ажлын онлайн платформын эрхийг сунгах, ашиглах зөвлөмж, гарын авлагыг түгээх;
- 7.9.5. Брайль үсэгтэй болон аудио ном, үндсэн сурах бичгийн тоог нэмэгдүүлэх чиглэлээр холбогдох тэнхим, нэгжтэй хамтран ажиллах;
- 7.9.6. Сургалтад ашиглах нээлттэй эх сурвалжтай ажиллах, заавар зөвлөмж гаргах;

НАЙМ. Бусад

- 8.1. МУБИС-ийн цахим сургалтын үр дүн, чанарыг холбогдох дүрэм журмын хүрээнд сайжруулалтыг тогтмол хугацаанд хийнэ.
- 8.2. Оюуны өмчийн зөрчилтэй холбоотой маргааныг оюуны өмчийн эрх, түүнд холбогдох хууль, журмаар шийдвэрлэнэ.

МУБИС-ИЙН ОНЛАЙН ХИЧЭЭЛД ТАВИХ ШААРДЛАГА

НЭГ. Нийтлэг зүйл

- 1.1. Энэхүү шаардлагыг онлайн хичээлийн агуулга бэлтгэх, боловсруулах, онлайн хичээлийн боловсруулалт болон хэрэгжүүлэлтийг үнэлэх, баталгаажуулах, шалгаруулахад жишиг болгож мөрдөнө.
- 1.2. Онлайн хичээл нь танилцуулга, агуулга (контент, сэдэв, модуль), арга зүй (суралцах үйл ажиллагаа, тэдгээрийн төлөвлөлт), үнэлгээ (суралцагчийн бие даан гүйцэтгэх ажил, үнэлгээтэй даалгаврууд хичээлийн явцын болон эцсийн үнэлгээний тестүүд), нэмэлт судлах материал гэсэн үндсэн бүтэцтэй байна.
- 1.3. Онлайн хичээл нь танилцуулга, хичээлийн төлөвлөлт, лекц, семинар, лаборатори, практик, бие даалт, хэлэлцүүлэг, сорилын сан, шалгалт гэсэн бүрдүүлбэр хэсэгтэй байна.

ХОЁР. Цахим хэрэглэгдэхүүнд тавих нийтлэг шаардлага

- 2.1. Толгой хэсэгт МУБИС-ийн таних тэмдэг (logo), нэр, гарчиг, боловсруулсан багш, холбоо барих утас, цахим хаяг зэрэг мэдээллийг байрлуулсан байх;
- 2.2. Агуулгыг үндсэн ба нэмэлт байдлаар ялгасан байх;
- 2.3. Зохиогчийн эрхийн зөрчилгүй байх;
- 2.4. Нээлттэй эх (open source) түлхүү ашигласан байх;
- 2.5. Хэлбэр, хэмжээ, өнгө зохицол, зохиомж нь дизайны шаардлага хангасан байх;
- 2.6. Нэмэлт материалын эх сурвалжийг оруулсан байх;
- 2.7. Холбоос (link) хэрэглэсэн байх;
- 2.8. Текстэн материал энгийн хэлбэр бүхий үсгийн фонтоор /UNICODE/ байх;
- 2.9. Үсгийн хэмжээ, мөр хоорондын зай үзүүлэх материалын зориулалтад тохирсон байх;
- 2.10. Зөв бичих дүрэм, найруулгын алдаагүй байх ба нэг өгүүлбэр дэх үгийн тоо 18-аас илүүгүй байх;
- 2.11. Өгүүлбэрийн бүтэц энгийн байна. (Нийлмэл урт өгүүлбэр аль болох ашиглахгүй байх)
- 2.12. Видео материалын дүрс, зохиомж нь чанарын шаардлага хангасан байх;
- 2.13. Аудио болон видео хэрэглэгдэхүүний яриа сонсголонтой, хэллэг тод, сонирхолтой байх;
- 2.14. График, хүснэгт, дүрс хангалттай харагдахуйц, гоо зүйн шаардлага хангасан байх;
- 2.15. Видео хичээл заах багшийн хувцас, гоёл, үс засалт энгийн байх;

ГУРАВ. Хичээлийн танилцуулгад тавих шаардлага

- 3.1. Хичээлийн зорилго, хичээлээр эзэмших мэдлэг, чадвар, хандлагын¹ жагсаалт, мөн сэдэв, модулийн талаар товч тусгана.
- 3.2. Танилцуулга хэсэгт суралцагчдад агуулгыг судлах, бие даан гүйцэтгэх даалгаврыг хийх, хэлэлцүүлэгт оролцох, сорил, шалгалт өгөх зэрэг үйл ажиллагааны арга, хэлбэр, хугацааны төлөвлөлтийг тодорхой тусгасан байна.
- 3.3. Хичээлийн танилцуулгыг текст, зураг, аудио, видео, анимейшн зэргийг нэгтгэсэн мультимедиа бүхий интерактив үзүүлэн хэлбэрээр боловсруулна.

ДӨРӨВ. Онлайн хичээлд тавих шаардлага

¹Тухайн мэргэжилтэн бэлтгэх хөтөлбөрийн 4.5-д заасан хичээлийн стандартыг мөрдлөг болгоно.

А. Лекц

- 4.1. Онлайн лекц нь видео лекц, уншиж судлах үндсэн материал, нэмэлт материал (эх сурвалж, нэр томьёо, тулгуур ухагдахууны лавлагаа, тайлбар болон нэмэлт мэдээлэл) гэсэн 3 хэсгээс бүрдэнэ.
- 4.2. Видео лекц нь синхрон (багш, суралцагчид интернэтээр шууд холбогдож зохион байгуулах), эсвэл асинхрон (видео бичлэгээ байршуулах) хэлбэртэй байж болно.
- 4.3. Танхим дах 90 минут лекцийг видео болгоход ихэвчлэн 40-50 минут болдог тул видео лекцийн хугацааг 40-50 минутаар төлөвлөнө. Нэг видеоны үргэлжлэх хугацаа 8 минутаас хэтрэхгүй. Тухайлбал, таны видео лекц 40 минут болсон бол 8 минутаар 5 хэсэг видео болгоно.
- 4.4. Онлайн лекцийн агуулгад тухайн шинжлэх ухааны сүүлийн үеийн мэдээлэл, онол, ойлголтууд болон тэдгээрийн хэрэглээ, тухайн салбарын эрдэмтэд болон өөрийн байр суурийг тусгасан, мөн нэмэлт материал болон холбогдох эх сурвалжийг дурдсан байна.
- 4.5. Онлайн лекц нь арга зүйн талаасаа сэдэлжүүлэх, таниулах, тайлбарлах, харьцуулах, маргаантай асуудал дэвшүүлэх, дүн шинжилгээ хийх, эргэцүүлэх, нэгтгэн дүгнэх, үнэлгээ дүгнэлт өгөх, аливаа асуудлыг шийдэх хувилбар зэргээр тухайн хичээлийн агуулгад боловсруулалт хийсэн байна.
- 4.6. Онлайн лекц нь хэлэлцүүлгийн хэсэгтэй байж болох ба хэлэлцүүлэх асуудал нь энэ шаардлагын 6-д тусгасан үйлд баримжаалсан, оюутнуудын ойлгож ухаарахад төвөгтэй болон хүндрэлтэй асуудлыг тодруулах, ташаа ойлголтыг залруулах зэрэгт суурилсан кейс асуудлаас бүрдсэн байна.
- 4.7. Онлайн лекцийг үнэлгээтэй даалгавар эсвэл шалгалтыг тодорхой түвшинд амжилттай гүйцэтгэсний дараа нээгддэг байдлаар тохируулж болно.

Б. Семинар

- 4.8. Онлайн семинарын агуулгад онол, үзэл баримтлал, үндсэн ойлголтуудыг хэрэгжүүлэх арга хялбаршуулан практик хэрэглээтэй холбох, практик үйлийн түвшинд туршлага, мөн мэдлэг, чадварыг өргөсгөх, гүнзгийрүүлэхэд чиглэсэн нэмэлт мэдээллийг тусгасан байна.
- 4.9. Онлайн семинарыг хэлбэр нь синхрон буюу вебинар хэлбэрээр зохион байгуулж болно.
- 4.10. Семинарын аргазүй нь тухайн агуулгыг бататгах, практик хэрэглээтэй холбох, нотлох, батлах, эргэлзээтэй асуудлуудыг шийдэх, үнэлэхэд чиглэнэ. Иймээс тайлбарлах, харьцуулах, дүн шинжилгээ хийх, дасгал даалгавар ажиллах, туршилт судалгаа хийх, эргэцүүлэх, үр дүнг үнэлэх, дүгнэлт гаргах зэрэг үйл ажиллагааг түлхүү тусгасан байна. Асуудал шийдвэрлэх арга зүй, төсөлд суурилсан арга зүй илүү тохиромжтой.
- 4.11. Онлайн семинарыг бүлэгт зориулан түгээмэл онол, зарчим, хууль, үзэл баримтлал, зүй тогтол зэргийг хэрхэн ашиглах талаар лавлагаа, тайлбар өгөх, нотлох, үнэлгээ хийх, дүгнэлт гаргах, жишээ баримтаар харуулах, асуулт, хариулт явуулах, бичил хэлэлцүүлэг хийх, үнэлгээ хийх, хичээлийн үр дүнг нэгтгэн дүгнэх хэлбэрээр зохион байгуулах ба үйл ажиллагааны дараалал, хэрэгжүүлэх арга зам нь тодорхой байна.

В. Лаборатори, практик

- 4.12. Онлайнлаар лабораторийн хичээлийг зохион байгуулах боломжтой ба лабораторийн ажил гүйцэтгэх үйл ажиллагааны төлөвлөгөө, туршилт, судалгаа хийх удирдамж, арга зүй, аргачлал, үйл ажиллагааны дараалал зэрэг мэдээллийг тусгасан, шинжилгээний үр дүнг нэгтгэх, үнэлгээ хийх, гүйцэтгэсэн туршилт, судалгааны дүнг бусдад мэдээлэх, үнэлэх, хэлэлцэх боломжийг хангасан байна.


- 4.13. Дадлага хэлбэрээр гүйцэтгэх, ур чадвар олгоход суурилсан хичээл нь онлайнаар зохион байгуулах бол гүйцэтгэх ажлын удирдамж, зөвлөмж, хийх ажлын даалгавар, жишээ, тайлбар болон асуулт хариулт явуулах, дадлага ажил хэлэлцэх, үнэлэх үйл ажиллагааг тусгасан байна.
- 4.14. Онлайнаар лаборатори, практикийн материал нь аудио, видео хэлбэртэй, гүйцэтгэх дасгал ажлын заавар, удирдамжаас гадна виртуал, симуляци хэрэглэгдэхүүнүүд байж болно.

Г. Үнэлгээтэй даалгавар болон бие даалтын ажил

- 4.15. Бие даан гүйцэтгэх даалгавар нь суралцагчдад тухайн шинжлэх ухааны онол, үзэл баримтлал, тулгуур ухагдахуун, ойлголтыг практик үйл ажиллагаанд буулган турших, эргэцүүлэх, үнэлэх, ингэснээр өөрийн мэдлэг, чадвараа бататгах, шинэ туршлага бий болгох, сурах арга барилаа хөгжүүлэхэд чиглэнэ.
- 4.16. Бие даалтын ажлын агуулга нь тодорхой 3-6 сэдэв, бүлэг сэдэв, эсвэл модулийн хүрээнд хичээлийн үндсэн болон нэмэлт материалтай ажиллаж, аливаа асуудал, үйл явц, үзэгдэл, мөн чанар, зүй тогтол, учир шалтгаан, үр дүн, нөлөөлөх хүчин зүйл, үр нөлөө, тэдгээрийг судлах, үнэлэх, тооцох, аргачлал зэргийн талаарх мэдлэгээ бататгаж, тодорхойлох арга, тэдгээрийн хүрээнд асуудал шийдвэрлэх чадвар эзэмшихэд чиглэсэн байна.
- 4.17. Үнэлгээтэй даалгавар болон бие даалтын ажил нь гүйцэтгэх даалгавар (assignment), заавар (instruction), шалгуур (rubric) гэсэн бүтэцтэй байна.
- 4.18. Бие даан гүйцэтгэх ажлын аргазүй нь сургалтын явцад болон амьдрал практикт тулгарах аливаа асуудлыг шийдвэрлэх арга замыг эрэлхийлэх, өөрийн шийдэл, хувилбарыг дэвшүүлэх, батлах, нотлох, зэргээр суралцагчдын судлан шинжлэх, бүтээлч эрэл хайлт хийх үйл ажиллагааг дэмжсэн байна.
- 4.19. Суралцагчдын бие даан хийх (дасгал, даалгавар, сорил, туршилт, төсөл гэх мэт) ажлын удирдамж, гүйцэтгэх хугацаа, онолын тайлбар, жишээ, өгөгдөл буюу даалгавар, үнэлгээний аргачлал зэргийг тодорхой зааж өгсөн байна. Онлайн бие даан гүйцэтгэх ажилд даалгавар илгээх, үнэлүүлэх, асуулт, хариулт (feedback) хийх нөхцөлийг хангасан байна.
- 4.20. Бие даан гүйцэтгэх ажил нь асуултад хариулах, бодлого, дасгал хийлгэх, зураг, график, диаграмм зуруулах эсвэл боловсруулах, эсээ (текст бичих талбар дээр бичих эсвэл цаасан дээр бичээд зургаар илгээх), илтгэл (үзүүлэн бэлтгээд илтгэж буйгаа бичлэгээр, үзүүлэнгээ файлаар upload хийх), төсөлт ажил, бүтээлийн сан, сурвалжилга, туршилт, тайлан (турших, үр дүнг задлан шинжлэх, нэгтгэн дүгнэх, статистик боловсруулалт хийх гэх мэт), зохион бүтээх (загвар, дизайн), сэдвийн арга зүйн боловсруулалт, сургалтын хэрэглэгдэхүүн, сорил, тест, эрдэм шинжилгээний бүтээл, судалгааны тойм, боловсролын бодлогын баримт бичгийн судалгааны тойм (хөтөлбөр, стандарт, боловсролын бодлого, үндэсний хөтөлбөрүүд гэх мэт) байж болно.
- 4.21. Үнэлгээтэй даалгавар болон бие даалтын ажлыг үнэлэх шалгуур нь тодорхой, хэмжигдэхүйц, нэгж оноотой хүснэгт хэлбэртэй байна.

ТАВ. Онлайн хэлэлцүүлэг зохион байгуулахад тавих шаардлага

- 5.1. Онлайн хэлэлцүүлэг нь тухайн чиглэлийн тулгуур ойлголт, ухагдахуун, тэдгээрийг амьдрал, практикт хэрэглэх, турших үйлийг төлөвлөх, гүйцэтгэх, хэрэгжүүлэх үйл явц, арга, аргачлалыг тодорхойлох, үзэл баримтлалыг харьцуулах, шинжлэх, нэгтгэн дүгнэх, үнэлэх зэрэг чадвар эзэмшүүлэхэд чиглэнэ.

- 
- 5.2. Онлайн хэлэлцүүлэг нь мэдлэг бататгахаас гадна асуудлыг олж харах, оновчтой асуух, ойлгомжтой хариулах, ойлголт, үзэгдэл үйл явцыг тайлбарлах, загварчлах, томъёолох, тэдгээрийн талаар ярилцах зэрэг чадвар эзэмшихэд нь туслах зорилгыг мөн агуулна.
- 5.3. Онлайн хэлэлцүүлгийг кейс болон асуулга байдлаар зохион байгуулах бөгөөд асуулт асуух, асуултад хариулах, санал өгөх, санаа бодол, төрсөн сэтгэгдэлээ илэрхийлэх, асуудалд шинжилгээ, судалгаа хийж үр дүнг батлах, нотлох, эсвэл үгүйсгэх зэргээр бүтээлчээр эргэцүүлэх, мэтгэлцэх арга хэлбэрийг гол болгосон байна.
- 5.4. Онлайн хэлэлцүүлэг нь дараах 4 төрөлтэй. Үүнд:
- 5.4.1 Асуулт бүхий хэлэлцүүлэг: Энгийн асуултад хариулах байдлаар хэлэлцүүлэг өрнүүлэх
- 5.4.2. Даалгавар бүхий хэлэлцүүлэг: Дасгал, даалгавартай адилхан. Гэвч хялбархан хийж болох дасгал, даалгавар байна. Дасгал, даалгаврыг суралцагч бүр хэрхэн гүйцэтгэж байгааг бусад суралцагчдад нээлттэй харуулж, хэлэлцэх. Тухайн хэлэлцүүлэгт суралцагч орсноор нэмэлт оноо цуглуулдаг.
- 5.4.3. Зөвлөмж бүхий хэлэлцүүлэг: Багш ямар нэгэн зүйлийг зөвлөн хэлэлцэх
- 5.4.4 Заавар бүхий хэлэлцүүлэг: Дараагийн хичээлтэй холбоотой шинэ зүйлийг суралцагч нарт алхамчилсан заавар байдлаар хэлэлцүүлэг өрнүүлэх
- 5.5. Онлайн хэлэлцүүлэг хийхэд суралцагчид болон багшийн оролцоо, тэдний байр сууриа илэрхийлэх үйл явц, хэлэлцүүлэгт баримтлах зарчим, арга тактик болон хугацаа (цаг/минут) зэргийн төлөвлөлт тодорхой байна.
- 5.6. Онлайн хэлэлцүүлгийг багш төлөвлөн зохион байгуулахаас гадна суралцагч тодорхой асуудлаар өөрийн хувилбарыг дэвшүүлж, бусад суралцагчидтай хэлэлцүүлэг зохион байгуулах боломжтой байна.

ЗУРГАА. Онлайн хичээлийг зохион байгуулахад тавих шаардлага

- 6.1. Бодит хугацаанд (realtime) сургалтын үйл ажиллагааг онлайнаар зохион байгуулж болно. Энэ тохиолдолд тодорхой нэг цагт бүх оролцогч нэгэн зэрэг онлайн байж хичээллэх болон хэлэлцэх үйл явц, түүний арга зүй, зохион байгуулалт нь оновчтой, тодорхой байхыг шаардана.
- 6.2. Лекц, семинар бүрийн дараа бодит бус хугацааны (unreal time) асинхрон хэлэлцүүлэг байх ба бүлэг сэдвийг судалсны дараа багшийн оролцоотой хэлэлцүүлэг зохион байгуулна.
- 6.3. Онлайн курс хичээлийн нийт хугацааны 30 хувь орчим хугацааг синхрон үйл ажиллагаанд зарцуулна. Тухайлбал, 16 долоо хоногийн 5-6 долоо хоногт синхрон үйл ажиллагаа зохион байгуулна.
- 6.4. Суралцагч онлайнаар хандалт хийх, лекц болон семинарын материалтай танилцах, хэлэлцүүлэгт оролцож асуулт асуух, хариулт бичих, бие даалт болон сорилт өгөх зэргийг иж бүрэн дэмжсэн байна.

ДОЛОО. Үнэлгээ

- 7.1. Үнэлгээний зорилт, үнэлэх зүйл болон хичээлийн үр дүн зэрэг нь хэрхэн холбогдож буй байдал, мөн үнэлгээний цар хүрээ, даалгавар зэргийг тайлбарласан байх ба МУБИС-ийн үнэлгээний даалгавар боловсруулах шаардлагыг хангасан байна.

- 7.2. Онлайн үнэлгээний тест, тестийн сан - Олон төрлийн тест (үнэн эсвэл худал, нэг хариулт сонгох, олон хариулт сонгох, харгалзуулах, дараалалд оруулах, нөхөх, бичиж хариулах, файл илгээх)-ийг агуулсан, ялгаатай түвшин (Блүүмийн 6 түвшин)-ийг тестүүдээс санамсаргүй сонгогдох боломжтой, тест болон түүний хариултад текст, зураг, аудио, видео зэргийг ашигласан байж болно.
- 7.3. Онлайн шалгалтыг нэг оюутнаас олон удаа авах боломжтой байх. Тухайлбал, явцын шалгалтыг 40 тестээр хоёр удаа авч болно. Багшийн тестийн сан арвин бол эхний шалгалтын асуулт, тестүүд дахин гарч ирэх магадлал бара байна. Харин, шалгалтын оноог тэдгээр оролдлогын дунджаар, ихээр, хамгийн сүүлийнхээр тооцож болно.
- 7.4. Оюутны бие даалтын үнэлгээг онлайн хичээлийн явцад гүйцэтгэсэн үнэлгээтэй даалгавруудын нийлбэрээр тооцож болно. Энэ нь оюутны ачааллыг тэнцвэржүүлэх, онлайн хичээлийн оролцоог идэвхжүүлэхэд эергээр нөлөөлдөг.

